



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (401)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Тогтоолд нэмэлт оруулах тухай*
- *Дүрэм шинэчлэн батлах тухай*
- *Хэлэлцээр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны тавдугаар сарын 30

№20 (401)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

719.	Үнэнбилэгийн Маамд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай	Дугаар 84	430
720.	Дагвадоржийн Мэндбаярт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 85	430
721.	Данзанямын Даваахүүд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай	Дугаар 86	430
722.	Жамбалдоржийн Бадраад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 87	430
723.	Түвдэнгийн Гун-Аажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 88	431
724.	Батхуягийн Шагжжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 89	431
725.	Пунцагийн Тогоод Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 90	431
726.	Жамбын Дашдондогт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 91	431
727.	Лувсангийн Хайсандайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 92	432
728.	Сугарын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 93	432
729.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 94	432
730.	С. Ариунболд, С. Ихбаяр нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай	Дугаар 95	437
731.	Б. Цэрэндаш, Ч. Лхагвадорж нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай	Дугаар 96	437
732.	Николай Стоянов Мариныг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 97	437

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

733.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 94	437
734.	Дүрэм шинэчлэн батлах тухай	Дугаар 95	439
735.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 96	440



2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 84

Улаанбаатар хот

Үнэнбилэгийн Маамд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад багш, хичээлийн эрхлэгч, захирлаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж математикийн ном, сурах бичиг туурвиж сургалтад нэвтрүүлэн, оюутан, сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, шавь нараа улсын болон олон улсын олимпиадад амжилттай оролцуулж, өндөр амжилт үзүүлэн залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Шинэ үе" дээд, дунд сургуулийн захирал Үнэнбилэгийн Маамд Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 85

Улаанбаатар хот

Дагвадоржийн Мэндбаярт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж үзэгч түмний сэтгэлд мөнхөрсөн үндэсний болон дэлхийн сонгодог олон жүжиг, киноны гол, туслах дүр бүтээж, монголын орчин цагийн тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэх, театр, киноны жүжигчдийн залуу халааг бэлтгэхэд оруулж байгаа дорвитой

хувь нэмрийг нь үнэлж Улсын драмын эрдмийн театрын жүжигчин Дагвадоржийн Мэндбаярт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 86

Улаанбаатар хот

Данзанямын Даваахүүд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай

Мал аж ахуйн үйлдвэрлэл, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж нутгийн хурдан удмын адууны угшлыг сайжруулан Үндэсний их баяр наадам, бүсийн болон шигшмэл хурдан морьдын уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулан, үндэсний уламжлал соёлоо хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Төв аймгийн Баянцагаан сумын иргэн, улсын тод манлай уяач Данзанямын Даваахүүд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 87

Улаанбаатар хот

Жамбалдоржийн Бадраад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгон, аж ахуй, санхүүгийн нөөц бололцоог дайчлан, төр, засгийн төв байгууллагуудын нийтлэг үйлчилгээний чанарыг сайжруулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Жамбалдоржийн Бадраад Монгол

Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2005 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

**Түвдэнгийн Гун-Аажавт Монгол Улсын
гавьяат багш цол хүртээх тухай**

Монгол Улсын Их сургуульд багш, декан, тэнхмийн эрхлэгчээр он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, технологийг боловсронгуй болгох, биофизикийн мэргэжлийн сургалт, судалгааг хөгжүүлэх, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын Их сургуулийн Биологийн

факультетийн биофизикийн тэнхмийн эрхлэгч Түвдэнгийн Гун-Аажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.БАГАБАНДИ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2005 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

**Батхуягийн Шагжжавт Монгол Улсын
гавьяат багш цол хүртээх тухай**

Их, дээд сургуульд багш, декан, захирлаар олон жил бүр бүтээлтэй ажиллаж гадаад хэлний сургалтын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгож, сургалтын ажлыг чанартай зохион байгуулах, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн сургалтын

стандартын шинжээч багш Батхуягийн Шагжжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.БАГАБАНДИ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2005 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

**Пунцагийн Тогоод Монгол Улсын хүний
гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж чих, хамар хоолойн өвчний оношилгоо, эмчилгээний шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж, эмчилгээний үр дүнг сайжруулан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын клиникийн төв эмнэлгийн

чих, хамар хоолойн тасгийн зөвлөх эмч Пунцагийн Тогоод Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.БАГАБАНДИ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2005 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

**Жамбын Дашдондогт Монгол Улсын
соёлын гавьяат зүтгэлтэн цол
хүртээх тухай**

Хэвлэл мэдээлэл, соёлын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үе үеийн бяцхан уншигчдын таашаалд нийцсэн хүүхдийн дуу, дуурь, кино, жүжиг, шүлэг, орчуулгын бүтээлүүд туурвиж, тэдний танин мэдэхүй, оюун санааг хөгжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж хүүхдийн зохиолч

Жамбын Дашдондогт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Лувсангийн Хайсандайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны салбар болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, нийгмийн шинжлэх ухааны шинэ салбар-монголын гадаад харилцаа, олон улс судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал Лувсангийн

Хайсандайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Сугарын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж монгол ардын урт, богинын болон зохиолын олон арван дууг чадварлаг дуулж, дуулах урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Үндэсний дуу, бүжгийн эрдмийн

чуулгын гоцлол дуучин Сугарын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, эрчим хүч, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, нисэх хүчин, татвар, даатгал, аудит, төр

захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХОДОЛМОРИЙН ГАВЬААНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Аюушийн Авирмэд - "MN-25 дугаар суваг" телевизийн ерөнхий менежер

5. Лхагвын Мөнхөө - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан

2. Бадамдоогийн Базарсүрэн - Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ахмад ажилтан

6. Гаваагийн Пүрэвбаатар - "Монгол" дээд сургуулийн зөвлөх багш

3. РавдангийнБолд - Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

7. Пэрэнлэйн Үржинлхүндэв - Монгол Улсаас БНСУ -д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

4. Даваагийн Дорждулам - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн, ахмад сэтгүүлч

8. Шаравын Цээсүрэн - Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын үсчин

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Доржготовын Чимэд- Юндэн- Тагнуулын
ерөнхий газрын дэд дарга, хошууч генерал

АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1. Бадарчийн Адъяа- Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн ариутгалын тасгийн эрхлэгч
2. Загдын Айлтгүй- Монгол даатгал компанийн Баянзүрх дүүрэг дэх салбарын захирал
3. Балжиннямын Алтанцэцэг- "Петровис" ХХК-ийн дэд захирал
4. Ядамын Аюурзана - Дорноговь аймгийн Сайншанд сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн физикийн багш
5. Халбалагийн Аятхан- Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрчимт эмчилгээний их эмч
6. Чойзонгийн Баатар- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны иргэн, ахмад орчуулагч
7. Өлзийдондовын Базаррагчаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 141 дүгээр цэцэрлэгийн багш
8. Балжирын Балдулмаа- МУБИС-ийн Багшийн сургуулийн математикийн тэнхмийн эрхлэгч
9. Содномдаржаагийн Батбаатар- Өнөөдөр" сонины 1 дүгээр орлогч эрхлэгч, "Таван цагариг" сонины ерөнхий эрхлэгч
10. Батбандийн Батлхам- УБТЗ-ын Сайншанд дахь эрчим хүч, ус хангамжийн 2 дугаар ангийн дизелийн машинч
11. Пүрэвдоржийн Болд- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Есөн-Од" ХХК-ийн ерөнхий захирал
12. Самбуугийн Бор- Нийслэлийн Мал эмнэлэг, үржлийн газрын эмчилгээ, үйлчилгээ хариуцсан их эмч
13. Цогт-Очирын Буян-Орших- Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын хормейстер
14. Дамбын Галсандорж- Үйлдвэр, худалдааны яамны Геологи, уул уурхайн бодлого, зохицуулалтын газрын дарга
15. Пэрэнлэйн Гүндсамбуу- Дорноговь аймаг дахь Улсын нөөцийн салбарын дарга
16. Нямаагийн Даваа- "Анод" банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
17. Сангийн Дагдан- Нийслэлийн Багахангай дүүргийн "Хангай" цогцолбор сургуулийн математикийн багш
18. Саналын Дашаа- "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн нярав
19. Дугарын Дашдондог- Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга
20. Намжаагийн Дашзэвэг- "Монгол" дээд сургуулийн захирал
21. Отгоны Дорж- Архангай аймгийн Хайрхан сумын Асгат багийн малчин
22. Лхамсүрэнгийн Дулмаа- Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
23. Минжүүрийн Дэмчигжав- Завхан аймгийн Нөмрөг сумын иргэн, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан
24. Балдандоржийн Ерэнчулуун- "Анод" банкны дотоод хяналтын албаны захирал
25. Дансрангийн Ёндонжамц- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн цахилгааны ерөнхий мэргэжилтэн
26. Аюушийн Жамбал- "НИК" ХК-ийн Улаанбаатар хот дахь нефть хангамжийн салбарын инженер
27. Лувсангийн Жамбалсанжид -Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Тамгын хэлтсийн дарга
28. Ганболдын Жаргалсайхан- UBS телевизийн "Тулах цэг" студийн захирал
29. Чүлтэмийн Лхагважав- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын зөвлөх
30. Жүгнээгийн Лхагвасүрэн- Увс аймгийн Холбооны газрын дарга



31. Нямдоржийн Лувсаншарав- Эрчим хүчний зохицуулах газрын эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны дарга

32. Тогоогийн Мандах- "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Холболтын байгууламжийн ашиглалтын газрын инженер

33. Лувсангийн Мичив- УБТЗ-ын Улаанбаатар татах хэсгийн машинч

34. Намидын Мөнхтүвшин- Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

35. Пүрэвийн Нямаа- Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч

36. Чимэддоржийн Нямжав- Хөвсгөл аймгийн "Эрх чөлөө" сонин эрхлэгч

37. Чүлтэмийн Отгонбаяр- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сангийн ерөнхийлөгч, "Од Консалтинг" хууль зүйн товчооны захирал

38. Хүрэлхүүгийн Отгоолой- ЭМШУИС-ийн дотоод шүүрэл цус судлалын тэнхмийн багш

39. Батсүхийн Оюун- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

40. Сундуйн Оюун-Эрдэнэ- Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 40 дүгээр сургуулийн бага ангийн багш

41. Балдангийн Пүрэв- Нийслэлийн тээвэр зохицуулалтын газрын автотээврийн хяналтын улсын байцаагч

42. Ламзавын Пүрэвжав- Булган аймгийн Булган сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн сургалтын менежер

43. Дэндэвийн Сандагсүрэн-Монголын мэдээ сонин ерөнхий эрхлэгч

44. Мөнхөөгийн Сувдаа-Нийслэлийн гоо сайхны үйлчилгээний "Сарнай төв"-ийн захирал

45. Самдангийн Сүхбаатар- "НИК" ХК-ийн борлуулалт маркетинг эрхэлсэн дэд захирал

46. Ширчингийн Сүхбаатар- "Өдрийн сонин"-ы орлогч эрхлэгч

47. Жүгдэрийн Сэрээтэр- МУИС-ийн Физик-электроникийн сургуулийн Цөмийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан

48. Пүрэвийн Туваанжав- Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн, ахмад багш

49. Бүдсүрэнгийн Түмэнбаяр- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхий менежер

50. Пүрэвжавын Хажидмаа- Нийслэлийн Сүхбаатар дүүрэг дэх "Гёте" дунд сургуулийн захирал

51. Санжаажамцын Хишгээ- Улсын Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн дотрын 3 дугаар хэсгийн их эмч

52. Сэдэдийн Хишгээ- Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн Эх барих эмэгтэйчүүдийн клиникийн их эмч

53. Раднаагийн Цогзолмаа- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга

54. Алтангэрэлийн Цэдэн-Иш- Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын удирдаач

55. Дондовын Цэдэн-Иш- МУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Эдийн засгийн сургуулийн ахлах тогооч

56. Жамцын Цэнд- Нийслэлийн Аудитын газрын аудиторч

57. Дашдаваагийн Цэндмаа-Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор 1 дүгээр ахлах сургуулийн газарзүйн багш

58. Содномбалын Цэрэн-Очир- ЭМШУИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхмийн багш

59. Чойдогийн Цэцэгээ- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 3 дугаар сургуулийн бага ангийн багш

60. Дугарсүрэнгийн Чилхаасүрэн- Хөгжим бүжгийн коллежийн бочин хөгжмийн багш

61. Дэнсмаагийн Шархүү- Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын эксперт

62. Бат-Очирын Ширчин- "Петровис" ХХК-ийн ерөнхий захирлын зөвлөх

63. Жамсрангийн Энхжаргал- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийтлэг үйлчилгээний газрын харьяа "Өргөө зочид буудал" ХХК-ийн ерөнхий захирал

64. Батнасангийн Энхтуяа- Монголын хүүхдийн ордны багш

65. Пүрэвийн Эрвээхэй-Ховд аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал



ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Санхүүжээний Батхүү- ЗХ-ний 303 дугаар ангийн нисэх аппарат хөдөлгүүрийн инженер, дэд хурандаа

2. Чойжилсүрэнгийн Тогоондорж - ЗХ-н ий 303 дугаар ангийн захирагчийн 1 дүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ендонгийн Адилбиш- Ховд аймгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний "Шим-Ус" ХХК-ийн захирал

16. Дугарын Зоосүрэн- Булган аймгийн Булган сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн сургалтын менежер

2. Жунгайн Алтанцэцэг- ЭМШУИС-ийн мэргэжил дээлүүлэх институтын арга зүйч

17. Доржнямын Март- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум дахь хөдөө аж ахуйн " Чагтай" ХХК-ийн зоо агрофермийн дарга

3. Самбуугийн Алтанцэцэг- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Эс энд Эй" ХХК-ийн захирал

18. Аюушийн Мөнхцэцэг- Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч

4. Аасүүгийн Анхмаа- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 160 дугаар цэцэрлэгийн арга зүйч

19. Должингийн Мэндбаяр- Нийслэлийн Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч

5. Цэдэнгийн Бат-Өлзий- Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим" ХХК-ийн борлуулалтын албаны байцаагч

20. Халтарын Мянгалаа- Говь-Алтай аймгийн Аудитын газрын шинжээч

6. Санжаагийн Баттулга- Булган аймгийн Шуудан холбооны газрын жолооч

21. Чулуунбатын Нэргүй- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын "Эдийн засаг, бизнесийн шинжилгээ, үнэлгээний төв"-ийн дарга

7. Чүлтэгийн Баяржаргал- Нийслэлийн "М Си Эс Интернэйшл" ХХК-ийн дэд захирал

22. Бямбаагийн Одонтунгалаг-Булган аймгийн Булган сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

8. Тарпаны Буршах- Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээ харилцсан мэргэжилтэн

23. Дугарын Оргодол- Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дөрвөлжин багт хүний бага эмч

9. Дондвийн Бямбаа - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харьяа Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн захирал

24. Гончигийн Отгонхүү- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн харьяа "Эрэл барилга" компанийн ерөнхий нягтлан бодогч

10. Жодов-Ишийн Борхүүхэн- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын "Зах зээлийн сургалт, судалгааны төв"-ийн дарга

25. Жадамбагийн Оюунаа- Нийслэлийн Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч

11. Цоодолын Гомбоцэвэг- Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

26. Бэгзийн Оюунцэцэг- "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн мастер тогооч

12. Баасандамбын Дагвадорж- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн сургалтын менежер

27. Аюушийн Оюунчимэг- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч

13. Лувсандоржийн Дашзэвэг- МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн инженер

28. Галхүүгийн Оюунчимэг- ЗХ-ний 137, 337 дугаар ангийн "Тамир" зангилгааны залгагч

14. Жалавжавын Долгор- Нялхсын клиник сувиллын дутуу нярай хүүхдийг торниулах тасгийн эрхлэгч

29. Наймалдайн Оюунчимэг- Хүүхдийн төлөө үндэсний газрын ерөнхий мэргэжилтэн

15. Чимэдбазарын Дуламсүрэн- ЗХ-ний 337 дугаар ангийн нягтлан бодогч

30. Бядаалайн Сандагсүрэн-Завхан аймаг дахь Монгол банкны салбарын захирал



31. Дугарсүрэнгийн Сарангэрэл- Төв аймгийн ЗДТГ-ын санхүү эдийн засаг, бодлого зохицуулалтын хэлтсийн дарга

32. Авирмэдийн Саранцэцэг- Нийслэлийн Аудитын газрын аудиторч

33. Сагьин Тилеубай-Баян-Өлгий аймгийн Сагсай сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч

34. Равжаагийн Төмөрхуяг- ЭМШУИС-ийн хангамж үйлчилгээний хэлтсийн хангамжийн нярав

35. Дашдоржийн Уртнасан- Орхон аймгийн Аудитын газрын ахлах аудиторч

36. Таравжавын Хандаа- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

37. Жадамбын Хачиндорж- Дорноговь аймгийн Аудитын газрын ахлах аудиторч

38. Дорждангийн Цогтбаяр- Сэлэнгэ аймгийн Баянгол сум дахь Улсын нөөцийн салбарын дарга

39. Дүгэрийн Цэвээн- Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний их эмч

40. Жамцын Цэенхорлоо - Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын ажилтан

41. Дагвын Шагжамба- МУИС-ийн Физик электроникийн сургуулийн Цөмийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

42. Баярбатын Энхжаргал-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан

43. Самдангийн Энхцэцэг-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

44. Шархүүгийн Энхцэцэг-Нийслэлийн барилга, худалдаа, үйлчилгээний "Турванбилэг" ХХК-ийн захирал

45. Лүндэгдаваагийн Эрдэнэбат-Нийслэлийн барилгын сантехник, салхивч, автоматик, угсралт үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн төслийн менежер

46. Даваагийн Эрдэнэ-Оргил-Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 10 жилийн сургуулийн химийн багш

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЭД ҮЛИАР:

1. Шаравын Бадарч- Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсийн 1 дүгээр хэсгийн дарга, цагдаагийн хошууч

2. Сэржээгийн Басан- ЗХ-ний 137, 337 дугаар ангийн бэлтгэл аэродромын тасгийн дарга, хошууч

3. Батчулууны Батбаяр- БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, дэд хурандаа

4. Доржцэрэнгийн Батбаяр- ЗХ-ний 337 дугаар ангийн үндсэн аэродромын тасгийн дарга, хошууч

5. Даржаагийн Батсуурь- ЗХ-ний 137, 337 дугаар ангийн хөдөлгүүрийн ахлах инженер, нөөц аэродромын тасгийн дарга, хошууч

6. Ганхуягийн Батхүрэл- ЗХЖШ-ын Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн мэргэжилтэн, дэд хурандаа

7. Дармаагийн Ганхуяг- ЗХ-ний 337 дугаар ангийн цахилгаан тусгай тоноглолын инженер, хошууч

8. Дондовын Ганхуяг- ЗХ-ний 303 дугаар ангийн цаг уурын мэдээллийн хэсгийн дарга, хошууч

9. Цэрэнгийн Даваажамц- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн 5 дугаар хэсгийн дарга, цагдаагийн хошууч

10. Жамбын Долгор- ЗХ-ний 303 дугаар ангийн нислэгийн их эмч, хошууч

11. Пунцагийн Санжааханд- ЗХ-ний 303 дугаар ангийн нислэгийн удирдагч, хошууч

12. Сосорбарамын Энхболд-ЗХ-ний 137, 337 дугаар ангийн тусгай тоноглолын инженер, хошууч

13. Магсарын Энхжаргал-ЗХ-ний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний техникч, ахмад

14. Цэнддоржийн Эрдэнэбаатар- ЗХ-ний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний техникч, ахмад

15. Дамдины Ядмаа- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн хошууч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

С.Ариунболд, С.Ихбаяр нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зэриг, авхаалж самбаа гарган гал түймрийн аюулаас хоёр хүний амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Нийслэлийн "Их бүл" ХХК-ийн захирал Содномбалжирын Ариунболд, "Сод тамгэ" ХХК-ийн ерөнхий захирал

Содномбалжирын Ихбаяр нарыг "Шударга журам" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Б.Цэрэндаш, Ч.Лхагвадорж нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зэриг, авхаалж самбаа гарган гал түймрийн аюулаас хоёр хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын гал унтраах 37 дугаар ангийн 4 дүгээр салганы гал сөнөөгч, ахлах ахлагч Базарваанийн Цэрэндаш, гал сөнөөгч, ахлах ахлагч

Чимиддоржийн Лхагвадорж нарыг "Шударга журам" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Николай Стоянов Мариныг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Болгар Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Болгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Николай

Стоянов Мариныг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоол, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2004 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 228 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 18 дугаар хавсралт болгон хэвсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 159 дүгээр тогтоол, "Бүрэлдэхүүнд

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Ч. УЛААН

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц. НЯМДОРЖ

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Ч.Улаан;
Дэд дарга:	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд;
	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Л.Хангай;
Гишүүд:	-Төв аймгийн Засаг дарга Ц.Энхбат;
	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар;
	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний бөхийн салбар хорооны дарга Н.Батсуурь;
	-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хурдан морины салбар хорооны дарга С.Баасанхүү;
	-Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд, Үндэсний сурын салбар хорооны дарга Г.Шийлэгдамба;
	-Барилга, хот байгуулалтын дэд сайд, Шагайн харвааны салбар хорооны дарга Ц.Дашдорж;
	-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн ёслол үйлчилгээний салбар хорооны дарга Р.Алтангэрэл;
	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Урлаг, соёлын арга хэмжээний салбар хорооны дарга Б.Мишигжав;
	-Улаанбаатар хотын ерөнхий менежер, Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооны дарга Г.Мөнхбаяр;
	-Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны дарга, Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар хорооны дарга Д.Болдхуяг;
	-Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга Д.Сандаг-Очир;
	-Төрийн ёслолын албаны дарга О.Нямдаваа;
	-Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Ц.Уугангэрэл;
	-Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ч.Наранбаатар;
	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Долоонжин;
	-Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш Ч.Ерөөлт.
Нарийн бичгийн дарга:	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Болдсайхан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

дүгээр сарын 9-ний өдрийн 90 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 4

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

П.ЦАГААН

Засгийн газрын 2005 оны 95 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрэм нь Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид "үндэсний зөвлөл" гэнэ/-ийн үйл ажиллагааг зохицуулна.

4. Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж хариуцна.

2. Үндэсний зөвлөл нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг боловсруулах, түүний хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар зөвлөмж гаргана.

5. Үндэсний зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:

3. Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэр гаргаж, түүний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг дүгнэнэ.

5.1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлага;

4. Үндэсний зөвлөл нь ажлаа Засгийн газарт танилцуулна.

5.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэл, үндэсний хэмжээний хөтөлбөр, төсөл;

5. Үндэсний зөвлөл нь зохих журмын дагуу хийсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

5.3. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд яамд, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

Хоёр. Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт

1. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

5.4. яамдын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны тайлан, захиалсан төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж байгаа байдал;

2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

5.5. суурь болон хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн хэмжээ;

3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн нь яам, Засгийн газрын агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн байгууллагын төлөөлөлтэй байна.

5.6. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх асуудал;

5.7. төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу сонгон шалгаруулсан шинжлэх ухаан, технологийн томоохон төслүүд;



5.8. шинжлэх ухаан, технологийн хэрэгжүүлж дууссан төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж байгаа байдал;

5.9. үндэсний инновацийн тогтолцоог бүрэлдүүлэн хөгжүүлэх асуудал;

5.10. эрдэм шинжилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт.

6. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлнэ.

Гурав. Үндэсний зөвлөлийн ажиллах журам

1. Үндэсний зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал байна.

2. Үндэсний зөвлөлийн хурлыг хагас жилд нэгээс доошгүй удаа, гишүүдийн 51-ээс доошгүй хувийн ирцтэйгээр хийнэ.

3. Үндэсний зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга дарална.

4. Үндэсний зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэсний зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулж болно.

5. Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга, тооцоо, судалгаа болон шаардлагатай бусад материалыг хурал эхлэхээс ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараана.

6. Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан эрдэмтэд, мэргэжилтнийг оролцуулж, тэдний санал, дүгнэлтийг сонсож болно.

7. Үндэсний зөвлөлийн хурлын дэгийг орлогч дарга батлан мөрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

1. 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Бухарест хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хооронд "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологи, эрүүл мэнд, спортын салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

ГАДААД ХЭРГИЙН
САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ

2. Энэхүү Хэлэлцээрийг баталсан тухай Румын Улсын Гадаад хэргийн яаманд мэдэгдэхийг

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД П.ЦАГААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12,

Төрийн ордон

☎ 329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэллэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5